

аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг дадлагын удирдагч багш /цагдаагийн ахлах дэслэгч Х.Наранбаатар, А.Алтантогоо/ нарт үүрэг болгосугай.

4.Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар Б/80

Дуурсах

Дадлагажуулагч багш
томилон цалин тогтоох тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код 924/, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох" журам /код 944/-ын 944.5, 944.6.4, "Байгууллагын даргын тушаал гаргах" /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/511 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/511 дүгээр тушаалаар жижүүрийн ахлах мөрдөгчийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн хошууч Ваанчигийн Ганзоригийн дадлагажуулагч багшаар Шуурхай удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/, Шаргалжуут тосгон дахь хэсгийн байцаагчийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн ахмад Мэдэхгүйн Отгонцэрэнгийн дадлагажуулагч багшаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/, Жинст сум дахь хэсгийн төлөөлөгчийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон цагдаагийн дэслэгч Монхдойн Цэнд-Аюушийн дадлагажуулагч багшаар Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/ нарыг тус тус томилсугай.

2. Цагдаагийн хошууч В.Ганзориг, цагдаагийн ахмад М.Отгонцэрэн, цагдаагийн дэслэгч М.Цэнд-Аюуш нарыг ажил албанд нь богино хугацаанд сургаж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах, гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан 3 сарын хугацаанд сурган дадлагажуулж, явц үр дүнгийн талаар илтгэх хуудсаар газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг дадлагажуулагч багш нарт даалгасугай.

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190301

3. Цагдаагийн хошууч В.Ганзориг, цагдаагийн ахмад М.Отгонцэрэн, цагдаагийн дэслэгч М.Цэнд-Аюуш нарт холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулахыг дадлагажуулагч багшид, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-д тус тус үүрэг болгосугай.

4. Цагдаагийн хошууч В.Ганзоригийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-11-ын 5 дугаар шатлалаар буюу 811251 /найман зуун арван нэгэн мянга хоёр зуун тавин нэг/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 30, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 20 хувиар,

Цагдаагийн ахмад М.Отгонцэрэнгийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-09-ын 5 дугаар шатлалаар буюу 748099 /долоон зуун дөчин найман мянга ерэн ес/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 30, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувиар,

Цагдаагийн дэслэгч М.Цэнд-Аюушийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТТ-10-ын 1 дүгээр шатлалаар буюу 616948 /зургаан зуун арван зургаан мянга есөн зуун дөчин найм/ төгрөгөөр тогтоож, цолны нэмэгдлийг 30, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг 25 хувиар тус тус тооцон бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5.Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



ЦАНХБАЯР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 одор

Дугаар Б/81

Дуурсах

Д.Жанчивсүрэнг олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлөх тухай


Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан "Олон нийтийн цагдаагийн дүрэм", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Богд сумын олон нийтийн цагдаа Доржхорлоогийн Жанчивсүрэнгийн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2. Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Д.Жанчивсүрэнгийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хурааж, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190305



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 6/82

Дуурсах

П.Лхагвасүрэнг олон нийтийн
цагдаагаар томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 2.3, 2.8, 3.1, 3.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гарган, сонгон шалгаруулалт, сургалтад хамрагдаж тэнцэж нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Пүрэвсүрэнгийн Лхагвасүрэнг тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн Богд сумын олон нийтийн цагдаагаар энэ оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.


2. Олон нийтийн цагдаа П.Лхагвасүрэнгийн дадлагажуулагч багшаар Богд сум дахь Сум дундын цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Ж.Мөнхтогоо/-ыг томилсугай.

3. Олон нийтийн цагдаагаар шинээр томилогдсон П.Лхагвасүрэнг сурган дадлагажуулж ажиллахыг дадлагажуулагч багшид, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/, хүний нөөцийн асуудлыг хариуцан ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шинээр томилогдсон олон нийтийн цагдаа нарт үнэмлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг тавьж олгохыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

5.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 07 сарын 05 одор

Дугаар Б/83

Дуурсах

Ц.Баярмааг ажлаас чөлөөлж, тэтгэмж
олгуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах журам" /код 136/-ын 136.5.2 "г", "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 5 зүйлийн 5.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн газрын даргын 2019 оны 09 дүгээр зөвлөлийн хуралдааны шийдвэрээр өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан үйлчлэгч Цэвээний Баярмааг 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлж, 18 /арван найм/ сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгосугай.

2. Ц.Баярмаатай зохих журмын дагуу тооцоо хийхийг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/, аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч А.Эрдэнэбал/, нярав /цагдаагийн дэд ахлагч Н.Элбэгсайхан/ нарт үүрэг болгосугай.

3. Ц.Баярмаад 18 /арван найм/ сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгуулах ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190309



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 6/84

Дуурсах

Д.Үүрцайхтай хөдөлмөрийн гэрээ байгуулж,
үйлчлэгчээр ажиллуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.3, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цагдаагийн газрын даргын 2019 оны 09 дүгээр зөвлөлийн хуралдааны шийдвэрээр үйлчлэгчээр ажиллах хүсэлт гаргасан Довдонгийн Үүрцайхыг 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, үйлчлэгчээр ажиллуулсугай.

2. Д.Үүрцайхтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч, Г.Алтанхуяг/, аж ахуйн ажилтан /цагдаагийн дэслэгч Б.Пүрэвсүрэн/ нарт даалгасугай.

3. Ч.Эрдэнэтуяагийн цалинг ТҮ-1-ийн 1 дүгээр шатлал буюу 432754 /дөрвөн зуун гучин хоёр мянга долоон зуун тавин дөрвөн/ төгрөгөөр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190311



Баянхонгор аймаг дахь
цагдаагийн газрын даргын
тушаал

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 6/85

Дуурсах

Л.Хуншагайг олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлөх тухай


Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан "Олон нийтийн цагдаагийн дүрэм", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газраас судлагдан, сонгон шалгаруулалтад тэнцэн, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэдийн нөөцийн жагсаалт"-д бүртгэгдэн, цагдаагийн мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа Баянхонгор сумын 7 дугаар багийн олон нийтийн цагдаа Лхагвасүрэнгийн Хуншагайн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2.Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Л.Хуншагайн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны болон нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хурааж, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190317



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 17 одор

Дугаар 5/86

Дуурсах

3.Гантулгыг олон нийтийн
цагдаагаар томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 2.3, 2.8, 3.1, 3.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гарган, сонгон шалгаруулалт, сургалтад хамрагдаж тэнцэж нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Зоригтын Гантулгыг тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн Баянхонгор сумын 7 дугаар багийн олон нийтийн цагдаагаар энэ оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.

2. Олон нийтийн цагдаа 3.Гантулгын дадлагажуулагч багшаар хэсгийн байцаагч /цагдаагийн дэслэгч Д.Ариунцэцэг/-ийг томилсугай.

3.Олон нийтийн цагдаагаар шинээр томилогдсон 3.Гантулгыг сурган дадлагажуулж ажиллахыг дадлагажуулагч багшид, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/, хүний нөөцийн асуудлыг хариуцан ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шинээр томилогдсон олон нийтийн цагдаа нарт үнэмлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны болон нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг тавьж олгохыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

5.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар Б/БТ

Дуурсах

Алба хаагчдын 2019 оны эхний хагас
жилийн ажлын үр дүнгээр цалин нэмж,
хасах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, мөн 38 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.11.3-ын "б", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Шагнал, урамшил олгох" /код 925/-ын 925.3.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Алба хаагчийн ажлыг үнэлэх" /код 111/-ын 111.4.2, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2019 оны 09 дүгээр зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 2019 оны эхний хагас жилд хамт олноо хошуучлан, идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажилласан 11 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь, 4 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 15 /арван тав/ хувиар, 20 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 10 /арав/ хувь, 1 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 5 /тав/ хувиар нэмж, 8 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 5 /тав/ хувь, 2 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 10 /арав/ хувь, 3 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь тус тус хасаж олгосугай.

(D)-Alban bichig-Tushaal-2019


20190321

2. Ажлын үр дүнгээр цалин нэмэх, хасах алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчдын цалинг заасан хувь, хэмжээгээр нэмж, хасаж олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

Цагдаагийн газрын даргын 2019 оны 07
дугаар сарын 17-ны өдрийн Б/87
дугаар тушаалын хавсралт

АЛБА ХААГЧДЫН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ЦАЛИН НЭМЭХ, ХАСАХ ТУХАЙ

№	д/д	Овог, нэр	Албан тушаал, цол
1 сар 20 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс			
1	1	Жаргалсайханы Наранбаатар	Ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа
2	2	Галбадрахын Алтанбагана	Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч
3	3	Түмэнжаргалын Ерэнбаяр	Эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн ахмад
4	4	Мөнхжаргалын Дамдиндорж	Мөрдөгч, цагдаагийн ахмад
5	5	Бөнтөрийн Алтангадас	Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч
6	6	Бямбаагийн Мөнх-Учрал	Эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч
7	7	Ганбатын Батсуурь	Жижүүрийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч
8	8	Батбаярын Бат-оргил	Жижүүрийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч
9	9	Загдсүрэнгийн Мөнхбаатар	Харуулын цагдаа, сургагч ахлагч
10	10	Намнангийн Намхайнямбуу	Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч
11	11	Алтанцэцэгийн Алтангэрэл	Цагдаа-зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч
1 сар 15 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс			
12	1	Умын Амаржаргал	Бууцагаан сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч
13	2	Цэдэндамбын Алтансүх	Жаргалант сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч
14	3	Цэрэнгийн Пүрэвдорж	Хүрээмарал сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч
15	4	Батаагийн Доржсүрэн	Баянбулаг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч
1 сар 10 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс			
16	1	Найманжингийн Өнөмөнх	Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч
17	2	Надмидын Өлзийжаргал	Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
18	3	Ариунболдын Алтантогоо	Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч
19	4	Батжаргалын Даваацэрэн	Нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч
20	5	Бакенгийн Иса	Мөрдөгч, цагдаагийн дэслэгч

21	6	Нэргүйн Отгонбаяр	Мөрдөгч, цагдаагийн дэслэгч
22	7	Даргиагийн Буянравжих	Мөрдөгч, цагдаагийн дэслэгч
23	8	Гарамын Цогтсайхан	Харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
24	9	Түндэвийн Чулуунбаатар	Харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
25	10	Батсайханы Баасанцэрэн	Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч
26	11	Нансалмаагийн Ариунболд	Бууцагаан сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
27	12	Ганболдын Сүхцэрэн	Галуут сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
28	13	Эрдэнэ-Очирын Мөнхгэрэл	Бичиг хэргийн эрхэлгч, бичээч, архивч, цагдаагийн ахлагч
29	14	Дашдамбын Батхуяг	Харуулын цагдаа, цагдаагийн ахлагч
30	15	Бат-Ирээдүйн Золбоот	Эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч
31	16	Энхбатын Пүрэвсүрэн	Харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч
32	17	Эрдэнэбаатарын Базарсад	Хамгаалалтын цагдаа, цагдаагийн дэд ахлагч
33	18	Энхбатын Эрдэнэбаатар	Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч
34	19	Бат-Эрдэнийн Лувсандорж	Баян-Овоо сум дахь цагдаа, цагдаагийн дэд ахлагч
35	20	Элбэгсайханы Даваацэрэн	Жаргалант сум дахь цагдаа, цагдаагийн дэд ахлагч
1 сар 5 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс			
36	1	Бадраагийн Мөнгөтулга	Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
1 сар 5 хувь хасаж олгох алба хаагчдын нэрс			
37	1	Жамбын Мөнхтогоо	Богд сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч
38	2	Цогбаярын Ганхөлөг	Жаргалант сум дарь Сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч
39	3	Сарангэрэлийн Анхбаяр	Бууцагаан сум дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч
40	4	Батбаярын Буянхишиг	Гурванбулаг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч
41	5	Гэрэлийн Бат-Орших	Заг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч
42	6	Баяртогтохын Жигмэд	Галуут сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч
43	7	Хүрэлтогоогийн Наранбаатар	Бөмбөгөр сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч
44	8	Очирбатын Амартүвшин	Баацагаан сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч

1 сар 10 хувь хасаж олгох алба хаагчдын нэрс			
45	1	Баатардашын Гантогтох	Баацагаан сум дахь цагдаа, цагдаагийн дэд ахлагч
46	2	Жаргалын Доржбат	Баянбулаг сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
1 сар 20 хувь хасаж олгох алба хаагчдын нэрс			
47	1	Далайжаргалын Балжинням	Баянговь сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
48	2	Доржхүүгийн Энхбат	Гурванбулаг сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч
49	3	Мягмарсүрэнгийн Бат-Эрдэнэ	Баян-Өндөр сум дахь цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

_____000_____



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 6/88

Дуурсах

Зарим алба хаагчдыг албан тушаалд
шилжүүлэн ажиллуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах” /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах” журам /код 908/-ын 908.2.2 дахь хэсгийн “б”, “в”, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.17-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлага болон алба хаагчдаас гаргасан хүсэлтийг харгалзан цагдаагийн ахлах ахлагч Доржхүүгийн Энхбатыг Гурванбулаг сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс Эрдэнэцогт сум дахь цагдаагаар, цагдаагийн ахлагч Санжаагийн Оюунцогтыг Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс Гурванбулаг сум дахь цагдаагаар, цагдаагийн ахлах ахлагч Амжилтмаагийн Болдбаатарыг Эрдэнэцогт сум дахь цагдаагийн үүрэгт ажлаас 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс тасалбар болгон чөлөөлж, энэ оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаагийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Дээрх алба хаагчдын ажлыг ажлын 3 хоногт багтаан хүлээлцүүлж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хөдөлгөөн хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-д үүрэг болгосугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчийн цалинг хэвээр тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190325

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар Б/89

Дуурсах

Э.Мөнхжалыг ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газраас судлагдан, сонгон шалгаруулалтад тэнцэн, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэдийн нөөцийн жагсаалт”-д бүртгэгдэн, цагдаагийн мэргэжлийн сургалтад хамрагдаж байгаа Бөмбөгөр сумын олон нийтийн цагдаа Энхжаргалын Мөнхжалын гэрээг 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2.Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Э.Мөнхжалын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хурааж, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190327



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 6/90

Дуурсах

Д.Энхбатад цол бууруулах сахилгын
шийтгэл оногдуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.5 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн бага, дунд, ахлах цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журам”-ын 5.1, 5.2.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246, 248 дугаар тушаалуудаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн цол олгох, бууруулах, хураан авах” /код 904/-ын 904.5.1, “Байгууллагын даргын тушаал гаргах” /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, “Сахилгын шийтгэл ногдуулах” /код 914/-ын 914.2, 914.3.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 10 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.15, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.4.1, 2.4.10 дахь хэсэгт заасныг тус тус зөрчсөн Эрдэнэцогт сумын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Доржхүүгийн Энхбатад Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх хэсэгт зааснаар цагдаагийн цолыг бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Цагдаагийн ахлагч Д.Энхбатад дахин зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг, хариуцсан алба хаагчтайгаа ажиллах ажиллагаа өдөр тутамд тавих хяналтаа сайжруулж, алба хаагчдынхаа сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зааварчилгаа өгч ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/-д үүрэг болгосугай.

3. Цагдаагийн ахлагч Д.Энхбатын хувийн хэрэг болон хүний нөөцийн санд баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/-т үүрэг болгосугай.

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190331

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 6/91

Дуурсах

Х.Цогтсайханыг олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Жинст сумын олон нийтийн цагдаа Хүдэрчулууны Цогтсайханыг хөдөлмөрийн гэрээг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2. Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Х.Цогтсайханы хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хурааж, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

20190333



БЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 25 одор

Дугаар 6/92

Дуурсах

Н.Дамчойчойгялыг олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлөх тухай


Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Баян-Овоо сумын олон нийтийн цагдаа Норовсамбуугийн Дамчойчойгялыг хөдөлмөрийн гэрээг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2. Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Н.Дамчойчойгялын хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хурааж, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190335



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 5193

Дуурсах

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэн,
ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.1, мөн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвшөөрлийн дагуу Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ц.Анхбаяр нь 2019 оны ээлжийн амралтаа авах болсонтой холбогдуулан 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс энэ оны 09 дүгээр сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-аар даргын зарим чиг үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Цагдаагийн газрын даргын өгсөн үүрэг, ажлын чиглэл болон ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан зарим зорилтын хүрээнд хийгдэх ажлуудыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д хариуцуулсугай.

3. Дээрх зарим чиг үүргүүдийг хэрэгжүүлэн биелэлтийг заасан хугацаанд гаргаж танилцуулан ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч Н.Өнөмөнх/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190337



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 8/79

Дуурсах

Дадлагын удирдагч багш
томилох тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/157 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын сургалт” /код 945/, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирлын хамтарсан 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/36, А/149 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Цагдаа-хууль сахиулах ажил” бакалаврын хөтөлбөрийн сургалтын 317, 322, 324, 3522 дугаар дамжааны сонсогч Ганбатын Сандаг-Очир, Пүрэвсүрэнгийн Өлзийбат, Анхбаярын Батбаяр, цагдаагийн дэд ахлагч Г.Эрдэнэбилэг нарыг “Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа”-ны чиглэлээр энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн дадлага хийлгэсүгэй.

2. Суралцагч цагдаагийн дэд ахлагч Г.Эрдэнэбилэгийн дадлагажуулагч багшаар Бөмбөгөр сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Х.Наранбаатар, сонсогч Г.Сандаг-Очир, П.Өлзийбат, А.Батбаяр нарын дадлагажуулагч багшаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо нарыг тус тус томилсугай.

3. Дадлагын хугацаанд суралцагч цагдаагийн дэд ахлагч Г.Эрдэнэбилэг, сонсогч Г.Сандаг-Очир, П.Өлзийбат, А.Батбаяр нарын дадлагын удирдамжид заасны дагуу сурган дадлагажуулж, хэрхэн ажилласан тухайгаа баримтжуулан, нууцлал,

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190299